



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар A/103

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээнээс
хамтран эзэмшигч хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны A/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Байчууд овгийн Жамсранжавын Ганзоригт (РЭ79093078), иргэн Мянгад овгийн Батмөнхийн Анаар-Эрдэнэ (РЭ89091719) нарын Мөрөн сумын 8 дугаар баг Согоот-5 503 тоотод байршилтай гэр, орон сууцны хашааны газрын зориулалттай 785м² эзэмшил газрын газар эзэмших эрхийн гэрчилгээнээс газар эзэмшигч иргэдийн өөрсдийнх нь хүсэлтийн дагуу хамтран эзэмшигч иргэн Жамсранжавын Ганзоригтыг хамтран эзэмшигчээс хасаж, газар эзэмших эрхийг Батмөнхийн Анаар-Эрдэнийн нэр дээр үлдээн, үлдсэн 4 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан Жамсранжавын Ганзоригтын газар эзэмших эрхийг улсын бүртгэлээс хасалт хийж, Батмөнхийн Анаар-Эрдэнэтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт шинээр хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзүл) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гардлыг эрхтэй болохыг дурдсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.



Захирамж 2024
671:010319